



**ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН  
ИХ СУРГУУЛИЙН РЕКТОРЫН  
ТУШААЛ**

2025 оны 02 сарын 27 өдөр

Дугаар А/60

Улаанбаатар хот

**Бүрэлдэхүүн сургуулийн захирлыг  
сонгон шалгаруулах тухай**

Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн дүрмийн 4.9.16 дахь заалт, сургуулийн “Хөдөлмөрийн дотоод журам”, Хүний нөөцийн бүрдүүлэлт, сонгон шалгаруулалтын журмын холбогдох заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус их сургуулийн бүрэлдэхүүн сургуулийн захирлыг сонгон шалгаруулах удирдамжийг хавсралтаар баталсугай.

2. Геологи, уул уурхайн сургууль, Менежментийн сургууль, Мэдээлэл, холбооны технологийн сургууль, Нийгэм, хүмүүнлэгийн сургууль, Хүнс, хөнгөн үйлдвэрлэл, дизайны сургууль, Хэрэглээний шинжлэх ухааны сургууль, Эрчим хүчний инженерчлэлийн сургуулийн захирлыг сонгон шалгаруулах комиссыг тухай бүр Ректорын тушаалаар батлуулж, сонгон шалгаруулах ажлыг батлагдсан удирдамжийн дагуу зохион байгуулах, нэгдсэн удирдлага чиглэлээр хангаж ажиллахыг Захиргааны удирдлагын газар (Б.Түмэндэлгэр)-т даалгасугай.

РЕКТОР



Т.НАМНАН

367040414



## ШУТИС-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ УДИРДАМЖ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулийн захирлыг сонгон шалгаруулахтай холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү удирдамжийг баримтална.
- 1.2. Сонгон шалгаруулалтыг зохион байгуулахдаа хүний эрх, нэр төр, мэргэжлийн нэр хүндийг хүндэтгэх, үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал үүслээр нь ялгаварлан гадуурхахгүй байх, тэгш хандах, хууль тогтоомж, шударга ёсыг дээдлэх, нууцыг хадгалах, нээлттэй ил тод, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зарчим баримтална.
- 1.3. Сонгон шалгаруулалттай холбогдон гарсан маргаан, гомдлыг сонгон шалгаруулалтын комисс зохиох журмын хүрээнд шийдвэрлэнэ.

### Хоёр. Бүрэлдэхүүн сургуулийн захирлын албан тушаалд нэр дэвшигчид тавих шаардлага

- 2.1. Бүрэлдэхүүн сургуулийн захирлын албан тушаалд нэр дэвшигч нь дараах шалгуур, шаардлагыг хангасан байна.
  - 2.1.1. Доктор (Ph.D)-с доошгүй эрдмийн зэрэгтэй, дэд профессороос доошгүй эрдмийн цолтой;
  - 2.1.2. Тухайн сургуулийн сургалт, судалгааны аль нэг чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн;
  - 2.1.3. Их, дээд сургуульд 10-аас доошгүй жил ажилласан;
  - 2.1.4. Багшлах болон эрдэм шинжилгээ, судалгааны ажлын дадлага, туршлагатай;
  - 2.1.5. Төр, боловсрол, шинжлэх ухааны байгууллагад удирдах албан тушаал эрхэлж байсан туршлагатай бол давуу тал болно.

### Гурав. Сонгон шалгаруулалтад бүртгүүлэхэд бүрдүүлэх баримт бичиг, шалгаруулалтад оролцох хүсэлт хүлээн авах, бүртгэх

- 3.1. Нэр дэвшигч дараах материалыг бүрдүүлнэ. Үүнд:
  - 3.1.1. Төрийн албан хаагчийн анкет, зурагтай (Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 600 дугаар тогтоолоор баталсан анкет);
  - 3.1.2. Сонгон шалгаруулалтад оролцогчийн гараар бичсэн хүсэлт;
  - 3.1.3. Иргэний үнэмлэхийн хуулбар (E-mongolia системээс лавлагаа авч болно);
  - 3.1.4. Боловсролын түвшин, эрдмийн зэрэг, цолыг тодорхойлсон баримт бичиг (хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах)-ийн хуулбар;
  - 3.1.5. Ажлын туршлагын шаардлагыг хангасан тухай нотлох баримт (нийгмийн даатгалын дэвтэр, хөдөлмөрийн дэвтэр, албан тушаалд томилогдсон, чөлөөлөгдсөн тушаал шийдвэр г.м.)-ийн хуулбар, лавлагаа;
  - 3.1.6. Бүтээлийн жагсаалт;
  - 3.1.7. ШУТИС-ийн хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөөтэй уялдуулан бүрэлдэхүүн сургуулийг хөгжүүлэх мөрийн хөтөлбөртэй байна. Хөтөлбөрийг 3 жилээр дараах агуулгатай боловсруулна. Үүнд:
    - 3.1.7.1. ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 13 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан “ШУТИС-2030



ШУТИС-ийн ректорын 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 760 дугаар тушаалын хавсралт

- стратеги төлөвлөгөө"-ний стратегийн үндсэн зорилт, чиглэлийн хүрээнд Тухайн бүрэлдэхүүн сургуульд хэрэгжүүлэх үйл ажиллагаа;
- 3.1.7.2. Тухайн сургуулийн орлогыг нэмэгдүүлэх, санхүүгийн үр дүнг дээшлүүлэх зорилгоор хэрэгжүүлэх ажил, тэдгээрийн хүлээгдэж буй үр дүн (нэр дэвшигч сургуулийн 2024 оны гүйцэтгэлийн тайлан, санхүүгийн төлөв байдлын мэдээллийг тухайн сургуулийн захиргаанаас авч болно);
- 3.1.7.3. Багш, ажилтан, суралцагчийн нийгмийн асуудал, ажиллах, сурах, судлах орчин, дэд бүтцийг сайжруулах чиглэлээр баримтлах бодлого, хэрэгжүүлэх үйл ажиллагаа;
- 3.1.7.4. Тухайн сургуулийн хөгжлийг хангахад чиглэсэн өөрийн санаачлан хэрэгжүүлэхээр төлөвлөж буй ажил, төсөл, хөтөлбөр;
- 3.1.8. "4 x 6"-ийн хэмжээтэй цээж зураг 2 хувь;

*Тайлбар: Бүрдүүлсэн баримт бичгийг нотариатаар баталгаажуулсан байхыг шаардахгүй бөгөөд баримт бичгийн үнэн зөвийг хүсэлт гаргасан иргэн өөрөө бүрэн хариуцна.*

- 3.2. Сонгон шалгаруулалтад оролцохыг хүссэн иргэн бүрдүүлсэн материалаа цаасан хэлбэрээр, А4 хэмжээний дугтуйнд хийж битүүмжлэн, зарласан хугацаанд ШУТИС-ийн хичээлийн 1 дүгээр байрны 211 тоот (Захиргааны удирдлагын газар) өрөөнд өөрийн биеэр хүлээлгэн өгнө. Хугацаа хожимдсон материалыг хүлээн авахгүй.
- 3.3. Захиргааны удирдлагын газар зарласан хугацаа дуусахад нэр дэвшигчийн бүртгэл үйлдэж, сонгон шалгаруулалтын материалын битүүмжилсэн дугтуйг задлахгүйгээр сонгон шалгаруулалтын комисст хүлээлгэн өгнө.

## **Дөрөв. Сонгон шалгаруулах үйл ажиллагаа**

Бүрэлдэхүүн сургуулийн захирлыг сонгон шалгаруулах үйл ажиллагаа нь 3 үе шаттай явагдана.

- 4.1. Нэгдүгээр шат. Анкетын шалгаруулалт хийх
- 4.1.1. Сонгон шалгаруулалтын комисс нэр дэвшигчдийн ирүүлсэн материалтай танилцаж, нэр дэвшигч тус бүрээр материалын бүрдэл хангасан эсэх, нэр дэвшигч нь 2.1-т заасан шалгуур шаардлагыг хангаж байгаа эсэх, боловсруулсан мөрийн хөтөлбөр нь 3.1.6-д заасан агуулгатай нийцэж байгаа эсэхийг нягтална.
- 4.1.2. Нэр дэвшигч нь 2.1-т заасан шалгуур шаардлагыг хангаагүй, бичиг баримтын бүрдэл дутуу бол тухайн нэр дэвшигчийг сонгон шалгаруулалтаас хасах үндэслэл болно.
- 4.1.3. Сонгон шалгаруулалтын комисс шаардлагатай гэж үзвэл баримт бичгийн үнэн зөвийг магадлах зорилгоор нэмэлт материал шаардах, тодруулга авах эрхтэй.
- 4.2. Хоёрдугаар шат. Мөрийн хөтөлбөрийг үнэлэх
- 4.2.1. Нэгдүгээр шатнаас шалгарсан нэр дэвшигчид мөрийн хөтөлбөрөө тухайн сургуулийн нийт хамт олон болон сонгон шалгаруулах комиссын гишүүдэд танилцуулна.
- 4.2.2. Нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрийн танилцуулга хийх хурлыг зохион байгуулах бэлтгэл ажлыг тухайн сургуулийн Захирлын туслах хариуцна.



ШУТИС-ийн ректорын 2025 оны 27 дугаар сарын 27-ны өдрийн 160 дугаар тушаалын хавсралт

- 4.2.3. Хуралд тухайн сургуулийн нийт үндсэн багш, ажилтны 75 хувиас доошгүй оролцсон тохиолдолд хүчинтэйд тооцно. Хурлын ирцийг бүрдүүлэх асуудлыг тухайн сургууль хариуцна.
  - 4.2.4. Хурлыг сонгон шалгаруулалтын комиссын дарга удирдан явуулна. Хурал даргалагч нэр дэвшигчдийг танилцуулж, анкетын шалгаруулалтын дүнг мэдээлнэ.
  - 4.2.5. Нэр дэвшигч бүр мөрийн хөтөлбөрөө 20 минутад багтаан танилцуулна. Асуулт, хариулт хүн тус бүр 2-3 минут байна.
  - 4.2.6. Хурлын төгсгөлд тухайн сургуулийн нийт багш ажилтнуудын нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөрт өгөх үнэлгээг нууц санал хураалтаар авна.
  - 4.2.7. Сонгон шалгаруулалтын комиссын төлөөлөл 1, тухайн сургуулийн багш, ажилтны төлөөлөл 4, нийт 5 хүний бүрэлдэхүүнтэй тооллогын комисс санал хураалтыг зохион байгуулна.
  - 4.2.8. Санал хураахын өмнө тооллогын комисс санал хураалтад оролцох багш, ажилтны тоог нарийвчлан гаргаж, баталгаажуулсан саналын хуудсыг тараана. Санал хураалтын хайрцгийг бүрэлдэхүүн сургуулиуд бэлтгэнэ.
  - 4.2.9. Нууц санал хураалтын хуудсыг тооллогын комисс тоолж, нэр дэвшигч тус бүрээр дүнг нэгтгэн, саналын хуудсуудын хамт сонгон шалгаруулалтын комиссын нарийн бичгийн даргад хүлээлгэн өгнө.
  - 4.2.10. Сонгон шалгаруулалтын комиссын гишүүдийн санал хураалтын хуудсыг комиссын нарийн бичгийн дарга тоолж, дүнг нэгтгэнэ.
  - 4.2.11. Хурлын тэмдэглэлийг бүрэлдэхүүн сургуулийн захирлын туслах хөтөлнө. Хурлын тэмдэглэлд сонгон шалгаруулах комиссын дарга гарын үсгээ зурж баталгаажуулна.
  - 4.2.12. Нэр дэвшигчийн нэг, хоёр дугаар шатнаас цуглуулах нийт оноо 100 хүртэл байна. Үүнд:
    - 4.2.12.1. Нэгдүгээр шатны шалгаруулалтад харгалзах үнэлгээ 20 хүртэл оноо байх бөгөөд сонгон шалгаруулалтын комисс үнэлнэ.
    - 4.2.12.2. Хоёрдугаар шатны шалгаруулалтад харгалзах нийт оноо 80 хүртэл байх бөгөөд комиссын оноо 30 хувь, хамт олны оноо 70 хувь байхаар тооцож гаргана.
  - 4.2.13. Сонгон шалгаруулалтын комисс нэр дэвшигч бүрээр нийт оноог тооцож онооны дарааллаар эрэмбэлэн, хуралд оролцож буй тухайн сургуулийн хамт олонд нээлттэй танилцуулна.
- 4.3. Гуравдугаар шат. Ярилцлага хийх
- 4.3.1. Эхний хоёр шатны шалгаруулалтаас хамгийн өндөр оноо авсан хоёр нэр дэвшигчид сонгон шалгаруулалтын дараагийн шат буюу Ректортой хийх ярилцлагад орох эрх олгож, холбогдох материалыг ШУТИС-ийн Ректорт хүргүүлнэ.
  - 4.3.2. Хамгийн өндөр оноо авсан хоёр нэр дэвшигчээс ШУТИС-ийн Ректор эцэслэн сонгож, тухайн бүрэлдэхүүн сургуулийн захирлын албан тушаалд томилно.
- 4.4. Сонгон шалгаруулалтын комисс нь нэр дэвшигчийн саналын хуудсуудыг А4-ийн хэмжээний дугтуйнд хийж битүүмжлэн, тухайн сургуулийн тамга дарж, дугтуйны гадна талд санал хураалтад оролцсон багш, ажилтны тоо, хурлын ирцийн хувийг бичиж Захиргааны удирдлагын газарт ирүүлнэ.